

Батлав.

“Эйч Энд Эйч” ХХК-ийн Ерөнхий Захирал



А.Цолмон

“Эмнэлэг бүрт чадамж, Эмч бүхэнд боломж”

ЗОРИЛТОТ АЯНЫ УДИРДАМЖ

“Эйч Энд Эйч” ХХК нь Монгол Улсын Эрүүл Мэндийн Яамнаас 2012 оныг “Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарын жил” болгон зарласантай холбогдуулан нийгмийн хариуцлагаа ухамсарлан улсын хэмжээнд ашиглагдаж байгаа бага оврын зөөврийн ЭХО аппаратанд чанарын хувьсгал хийх, анхан шатны оношлогоонд дэвшилт гаргах зорилгоор энэхүү аяныг албан ёсоор зарлаж байна.

Зорилт:

- ЭХО-ны Эмч нарын чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор орчин үеийн дижитал технологи бүхий ЭХО аппаратыг хэрэглэхийг хүссэн эмч бүхэнд боломжийг бүрдүүлэх
- БНСУ-ын Samsung Medison брэндийн SonoAce R3 аппаратыг зах зээлийн үнээс хамаагүй хямд үнээр Монголынхоо эмч нарт нийлүүлэх / 50% /
- Монгол хүний бие эрүүл байж, урт насалж, сайхан амьдрахад нь бага ч болов тус болох үүднээс ЭХО оношлогооны шинэ боломжуудыг нэвтрүүлэх

Хугацаа: 2012.06.16 – 2012.12.31

Хамрах Хүрээ: I, II, III шатлалын эмнэлгүүд, хувийн эмнэлгүүд, хүссэн эмч бүхэнд

- Хэрвээ та сум, хороо, өрхийн эмнэлгийн эмч бол
- Хэрвээ та БНХАУ-д үйлдвэрлэсэн зөөврийн ЭХО аппарат хэрэглэдэг түүнийгээ сайжруулах хүсэлтэй бол
- Хэрвээ та цаашид ЭХО-ны эмч болохоор шийдсэн бол бидэнд хандаарай.

Үйл ажиллагааны чиглэл:

- Хэвлийн хөндийн
- Эмэгтэйчүүдийн
- Зүрх судасны
- Хөхний
- Захын эрхтний зэрэг ЭХО-гоор оношлож болох бүхий л салбарт ажилладаг эмч нарт нээлттэй.

Санхүүжилт :

“Эйч Энд Эйч” ХХК нь 2007 оноос эхлэн Samsung Medison брэндийн ЭХО аппаратыг Монгол улсад албан ёсоор борлуулж эхэлсэн бөгөөд энэ салбартаа тэргүүлэх байр суурийг эзэлдэг билээ.

Одоогоор улсын болон хувийн хэвшлийн том, жижиг нийлсэн 300 шахам эмнэлэгт ЭХО аппаратаа нийлүүлээд байна.

Бид өөрсдийн туршлага, энэ хугацаанд хүлээн авсан мэдээлэлдээ үндэслэн Монгол улсын сум, хороо бүрт ашиглагдаж байгаа ЭХО аппаратуудын ихэнх нь хуучирсан, технологийн хувьд хоцрогдсон, орчин үеийн оношлогооны шаардлага хангахгүй байна гэж дүгнэлээ.

“Эйч Энд Эйч” ХХК нь Samsung Medison брэндийн Монгол улс дахь албан ёсны борлуулагчаар ажиллаж байх хугацаандаа аль болох олон эмч, эмнэлгийн байгууллагад сайн чанарын ЭХО аппаратыг хаа ч байхгүй хямд үнээр нийлүүлэхийг чармайн ажиллаж ирсэн билээ.

Тиймээс бид Samsung Medison компанитай томоохон тохиролцоонд хүрч 2012 оныг дуустал /6 сарын турш/ SonoAce R3 маркийн ЭХО аппаратыг зах зээлийн үнээс 50- өөс доошгүй хувийн хямдралтай үнээр худалдан авах боломжийг бүрдүүлээ.

Өөрөөр хэлбэл БНХАУ-д үйлдвэрлэсэн хар цагаан ЭХО аппаратын үнээр БНСУ-д үйлдвэрлэсэн дэлхийд тэргүүлэх байр эзэлдэг Samsung Medison брэндийн өнгөт доплер бүхий аппаратыг худалдан авах боломжийг ЭМЧ танд олгож байна.

Мөн бид төлбөрийн нөхцөлийг уян хатан болгох үүднээс гэрээ байгуулахад 50%, үлдэгдэл төлбөрийг компаний лизингээр сарын 1%-ийн хүүтэйгээр 6 хүртэлх сарын хугацаатайгаар худалдан авах боломжийг олгож байна.

Жишээлбэл: Та SonoAce R3 ЭХО аппаратыг 2 датчик, зориулалтын тавиур, принтер, зөөвөрлөхөд хялбар дугуйтай цүнхний хамт 11,5 сая төгрөгөөр худалдан авах боломжийг танд олгож байна. Үүнээс гэрээ байгуулахдаа 50% болох 5,75 сая төгрөгийг бэлнээр төлж үлдсэн төлбөрийг 6 сарын хугацаанд тэнцүү хувааж төлөх боломжтой юм. Энэ аппаратын дэлхийн зах зээл дээрх үнэ нь 17-28 сая төгрөгийн үнэтэй байдаг тул даруй 40-60%-ийн хямдралтай үнээр авах боломжтой боллоо гэсэн үг юм.

Та аянд хэрхэн хамрагдах вэ?

- “Эйч Энд Эйч” ХХК-ийн ажилтанд хандан “Эмнэлэг бүрт чадамж, Эмч бүхэнд боломж” Зорилтот Аянд хамрагдах хүсэлтийг бөглөх шаардлагатай.
- Дараа нь бид тантай холбогдон таны эрхэлж байгаа ажил, албан тушаал, санхүүгийн нөхцөл байдалтай танилцан “Хамтран ажиллах гэрээ”-г албан ёсоор байгуулна.

Танд өгөх зөвлөгөө

- ЭХО оношлогоо нь хамгийн өртөг багатай, эрсдэлгүй оношлогоо тул өвчтөн хамгийн их хамрагддаг
- ЭХО оношлогоо нь төлбөртэй хийгддэг тул та маш хурдан аппарат худалдан авсан зардлаа нөхөх боломжтой
- Мөн та өөрийн ажилладаг орон нутгийн пүүс, компани, хувь хүмүүст хандан санал тавьснаар Монгол хүнийхээ төлөө гэсэн чин сэтгэлтэй хүмүүсээс санхүүгийн дэмжлэг авах бүрэн боломжтой

SonoAce R3 ЭХО аппаратын давуу талуудаас

- 15 инчийн LCD өнгөт дэлгэцтэй
- Нэгэн зэрэг 2 датчик холбох боломжтой
- Харьцангуй хөнгөн
- Зориулалтын 4 дугуй бүхий тавиуртай
- Өнгөт доплертэй
- 3D функцтэй
- USB 2.0 оролттой
- Зориулалтын хамгаалалт бүхий дугуйтай цүнхтэй



Бид “Эмнэлэг бүхэнд чадамж, Эмч бүрт боломж” Аяныг бид илүү өргөн хүрээтэй, төр олон нийтийн бодитой дэмжлэг авах үүднээс ЭМЯ, ЭМГ, Нийслэл, Аймгийн ЭМГ, Дэлхийн зөн, НҮБ-ын Хүн Амын Сан зэрэг байгууллагуудад хандан албан ёсоор хандан хамтран ажиллах санал тавих болно.

Бидэнтэй хамтран ажиллах хүсэлтэй хүн бүхэнд манай үүд хаалга үргэлж нээлттэй байх болно.

Сайн үйлс бүхэн дэлгэрэх болтугай.

“Эйч Энд Эйч” ХХК-ийн Хамт олон